



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/1425

Булган сум

### Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД81-16-20, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV дүгээр хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2023 оны XIV/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын 2 дугаар баг хүүхдийн тоглоомын талбайн зураг төсөл зохиогч “Үндсэн төсөл” ХХК-тай 3,000,000 (гурван сая), Булган сумын төвд нийтийн эзэмшлийн авто зогсоолын талбай нэмгэдүүлэх 11 дүгээр байр зураг төсөл зохиогч “Үндсэн төсөл” ХХК-тай 4,000,000 (дөвөн сая), Булган сум 5 дугаар баг гудамж, зам, талбайн тохижилт зураг төсөл зохиогч “Аслаан” ХХК-тай 8,000,000 (найман сая), Булган сумын нийтийн биеийн тамирын талбай байгуулах тохижилтын ажлын зураг төсөл зохиогч “Үндсэн төсөл” ХХК-тай 15,000,000 (арван таван сая), Булган сумын эрүүл мэндийн замын зураг төсөл зохиогч “Энхийн жаргал констракшн” ХХК-тай 19,800,000 (арван есөн сая найман зуун мянга), Нэгдсэн эмнэлэгийн хүүхдийн тасгийн засварын ажлын зураг төсөл зохиогч “Үндсэн төсөл” ХХК-тай 5,000,000 (таван сая) төгрөгөөр тус тус гэрээ шууд байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг “Үндсэн төсөл” ХХК (Г.Төрмандах), “Аслаан” ХХК (Ж.Банзрай), “Энхийн жаргал констракшн” ХХК (Э.Ундармаа)-д тус тус үүрэг болгосугай.

3. Дээр дурдсан ажлуудын зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж хүлээн авахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4. Дээрх ажлуудын санхүүжилтийг тухайн төсөл арга хэмжээний батлагдсан төсвөөс гэрээнд заасан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6830010402